

Мэргэжлийн цэрэгт суурилсан ахлагчийн сургалт сөрөн тэсвэрлэх чадавхад үзүүлэх нөлөөлөл

Ц.Оюунчимэг

Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын политехник коллеж

Key words:

National resilience capacity, professional military, A non-commissioned officer (NCO), training system, professional standards

Abstract: This article addresses the training system of non-commissioned officers (NCOs) within the Mongolian Armed Forces, which constitutes a vital component of the national defense structure based on a professional military. The study explores the necessity and potential for enhancing the current system and proposes improvements grounded in the military training experiences of both domestic and foreign countries, as well as the demands of key stakeholders. It also emphasizes the importance of implementing the program “Call of the Nation From Conscription to Professional NCO,” aimed at providing vocational education for conscripted soldiers, along with the short-term initiative “No One More Professional Than Me,” which promotes military careers among youth in collaboration with civil-military organizations. The research methodology involved document analysis, comparative analysis, case studies, and data-driven evaluation methods.

Удиртгал

Дэлхийн гео стратеги, геополитикийн нөхцөл байдал ээдрээтэй болж буй энэ цаг үед болзошгүй аюул, заналхийлэл, гамшгаас урьдчилан сэргийлэх, төр, нийгмийн үйл ажиллагааг сэргээн босгох чадавхыг хангах зорилгоор “Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги”-ийг “УРЬТАЖ МЭДЭЭД, ТОСОЖ БЭЛДЭЭД, ТЭСЭЖ ҮЛДЭХ, ТҮРГЭН СЭРГЭХ” гэсэн үндсэн үзэл санаанд тулгуурлан боловсруулахыг зорьж байна. Харин энэ үзэл санааны амин сүнс нь “ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ, хүн бүр ЭХ ОРОНЧ МОНГОЛ байх явдал”¹ хэмээн үзсэн.

Дээрх бодлого, үзэл санааны хүрээнд батлан хамгаалах салбар “Батлан хамгаалах тогтолцоонд сэргэлт хийж, эх оронч үзэлд суурилсан хүн төвтэй бодлого хэрэгжүүлж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлээд байгаа билээ.

Монгол Улс батлан хамгаалах тогтолцооны үндсээ төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл

¹ <https://president.mn/> Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудас. 2025 оны мэдээлэл;

удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно² хэмээн, Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги, хөтөлбөртөө “цэргийн мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг байгуулах³”, “Мэргэжлийн, өндөр чадамжтай зэвсэгт хүчнийг бүрдүүлэх, бэхжүүлэхийн нэг гол хүчин зүйл нь цэргийн сургалт, бэлтгэл, байнгын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх ололтуудыг нэвтрүүлж, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх явдал юм⁴” гэж заажээ.

Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг хамгаалах тэмцлийн шаардлагатай бүх арга хэмжээнд улс, нийгмийг бэлтгэх, иргэдийн оролцоотой хамгаалалт болон цэргийн хамгаалалтыг цогцоор нь авч үздэг⁵.

Энэхүү өгүүллээр улс эх орны батлан хамгаалах тогтолцооны нэг чиглэл болсон мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний ахлагчийн сургалтын асуудлыг хөндөж, ахлагчийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага болон боломжийг судалсан болно.

Судалгаанд дотоод, гадаадын улс орнуудын нөхцөл байдал, цэргийн сургалтын туршлага, мөн оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд тулгуурлан ахлагчийн албаны нэр хүнд үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэднийг тасралтгүй хөгжүүлэх сургалтын тогтолцооны санал дэвшүүлсэн.

Мөн хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох “Эх орны дуудлага эр цэргийн албанаас Мэргэжлийн ахлагч” хөтөлбөр болон залуучуудад цэргийн мэргэжлийг сурталчлах “Хэн ч надаас илүү мэргэжлийн байж чадахгүй” богино хугацааны сургалтын хөтөлбөрийг иргэн-цэргийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхийн ач холбогдлыг тодорхойлсон. Судалгааны аргачлалд баримт бичгийн шинжилгээ, харьцуулалт, кейс судалгаа болон мэдээлэлд суурилсан дүн шинжилгээний аргуудыг ашигласан болно.

Судалгааны эх сурвалжид Монгол Улсын батлан хамгаалах болон боловсролын бодлоготой холбоотой хууль, эрх зүйн баримт бичгүүд, гадаад улс орнуудын цэрэг, улс төрийн нөхцөл байдал цэргийн сургалтын туршлага, сургамж, шинжлэх ухааны нэг сэдэвт бүтээлүүдийг хамруулсан.

² “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. 2.2 заалт;

³ “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 127 дугаар тогтоолын хавсралт.3.1 заалт;

⁴ “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;

⁵ “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал” Swedish Defense University орчуулгын бүтээл;

Үндсэн хэсэг

Нэг. Дэлхийн зарим улсуудын ахлагч нарын сургалт

Дэлхийн ихэнх улс орнууд хүйтэн дайны аюулаас ангижирсантай холбоотойгоор зэвсэгт хүчиндээ ихээхэн өөрчлөлтүүдийг хийх болсон. Их хүчний эсрэг их хүчээр байлдаж байсан Дэлхийн хоёрдугаар дайны сургамж тактик нь америкчуудын хувьд Вьетнам, Солонгосын дайн, харин Оросуудын хувьд Чечени, Афганистанд хийсэн байлдааны ажиллагаануудын сургамжуудаар өөрчлөгдсөн. Байлдааны ажиллагаа болон дэлхий нийтийн нийтлэг дайсан болсон алан хядагчид их хүчээр биш харин жижиг бүлгийн түйвээн бусниулах, хорлон сүйтгэх ажиллагаанууд явуулж байв.

Халдварт өвчний тархалт, байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох зэрэг нь улс орнуудад уламжлалт бус үүрэгт бэлтгэгдсэн өндөр мэргэшсэн хөрвөх чадвартай байнгын мэргэжлийн бүрэлдэхүүнтэй зэвсэгт хүчинтэй байхыг шаардсан.

АНУ, Голланд, Их Британи, Австрали, Герман, ОХУ зэрэг дэлхий дахины цэргийн хөгжлийг тодорхойлж буй улсууд зэвсэглэл техникийн хөгжилд анхаарал хандуулахын зэрэгцээ түүнийг удирдах, ажиллуулах ахлагч нарын мэргэжлийн сургалт бэлтгэлд түлхүү анхаарч шат дараалсан албан тушаалуудад тодорхой шаардлага тавин түүний хэрэгцээг хангасан сургалтуудыг шат бүрд нь явуулж, шаардлага хангасан албан хаагчийг дэвшүүлдэг. Тухайлбал АНУ-ын армийн удирдах албан тушаалын ахлагч нарын хувьд бүлэг, тасгийн захирагчаас эхлээд тэргүүн ахлагч хүртлээ шат шатны удирдах албан тушаалын дамжаа болон тодорхой тооны мэргэжлийн мэргэшүүлэх сургалтад хамрагддаг. Эдгээр сургалтад хамрагдсан удирдах албан тушаалын ахлагч нар өөрийн бүлэг, тасгийн цэргийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг тухайн шатны захирагч даргын баталсан хуваарийн дагуу зохион байгуулж явуулах ба тэдний сахилга бат, хувцаслалт, үүрэг гүйцэтгэлтийн байдлаар өөрийн захирагч даргын өмнө хариуцлага хүлээдэг байна. Энэ мэтчилэн ахлагчийн шаталсан дамжаанууд цол, албан тушаалтай уялдсан, өөр өөрийн онцлогтой бөгөөд ахлагч нараа тухайн албан тушаалд бүрэн бэлддэг. Сүүлийн шатны сургалт болох тэргүүн ахлагчийн дамжааны сургалтын агуулга нь операц, стратегийн шатны мэдлэгийг тухайн улсынхаа армийн батальоны захирагч болон түүнээс дээш албан тушаалын ахлах офицерыг бэлтгэдэг дамжааны сургалтын агуулгатай энэ зэрэгцэхүйц мэдлэгийг олгож мэргэшүүлдэг байна. Эдгээр сургалтууд нь ахлагч нарыг бүх түвшний байлдааны болон бусад талбарт бүтээлчээр ажиллах боломжийг бүрдүүлдэг ба офицеруудын ажлын ачааллыг хөнгөвчлөн тэднийг онол, судалгаа, шинжилгээний тал руу түлхүү ажиллах боломжийг бүрдүүлдэг.

Улс орнуудын цэргийн сургалт хэв загвар уламжлалт байдлаа өөрчилж,

хуурай газар, агаар, сансар, далай тэнгис төдийгүй кибер орон зайд өрнөх зэвсэгт тэмцэлд мэргэжлийн, тусгай ур чадвартай, бие бялдар, сэтгэл зүйн болон технологийн хэрэглээний түвшин өндөртэй, байгаль цаг уур, газар орны ямар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх ЦАХ-ыг бэлтгэж байна.

Гадаадын мэргэжлийн армиудын сургалтын үе шат нь богино хугацааны эрчимтэй сургалтаар цэргийн мэргэжил эзэмшүүлж, шаталсан дамжааны хэлбэрээр мэргэжлийн ур чадварыг хөгжүүлж, мэргэшүүлдэг нийтлэг чиг хандлагатай байна⁶.

Мөн танхимын хичээлд ноогдох хугацааг багасгах замаар дадлага голлосон хээрийн гаралт, полигоны сургалтаар дадлагажуулахад онцгой анхаарч, сургалтыг шинэ мэдлэг олгох, бататгах, үзүүлэх, сурган зааварлах тэмцээний хэлбэрээр зохион байгуулах аргуудыг өргөн ашиглаж байна.

Ахлагч нар ахлагч бүрэлдэхүүнийхээ мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч, зөв хандлагыг төлөвшүүлэх, албаараа бахархах, тогтвортой ажиллах сэдлийг өгч, цэргийн мэргэжлээрээ мэргэшсэн мастер дадлагын багш болон сургагч нараар ахлагчийн сургалтыг гардан зохион байгуулдаг байна. Дадлагын багш (сургагч) бэлтгэх бодлогыг ахлагчийн сургалтын тогтолцоогоороо дамжуулан хэрэгжүүлдэг⁷.

Мэргэжлийн зэвсэгт хүчний мөн чанар бол бие бүрэлдэхүүний мэргэжилтэй, цэргийн мэргэжилд мэргэшсэн байдалтай, онцлог шинжтэй, бүр тодруулбал, эрх мэдэл, хариуцлагатай, эв нэгдэлч чанартай холбогддог.

Чадварлаг, мэргэжлийн зэвсэгт хүчинтэй байхын нэг шалгуур нь мэргэжлийн мэргэшсэн ахлагч бэлтгэх сургалтын бодлогоо оновчтой тодорхойлж, сургалтын тогтолцоо, мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөрийг даргалах болон гүйцэтгэх албан тушаалын ахлагч нарын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, эдлэх эрх, оролцогч талуудын эрэлт хэрэгцээтэй нийцүүлэн, эрчимтэй тасралтгүй, шаталсан бүтэцтэй байхаар боловсронгуй болгох явдал юм.

Хоёр. Монгол Улсын мэргэжлийн цэрэгт суурилсан ахлагчийн сургалт

Монгол Улс мэргэжлийн зэвсэгт хүчинтэй болох зорилт дэвшүүлэн, сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний үндэс болсон ахлагч нартай холбоотой асуудлуудаар томоохон ажлуудыг хийсэн.

Ахлагчийн даргалах албан тушаалууд болох Тасгийн захирагч, Салааны захирагчийн орлогч, Ротын ахлагч, Штабын ажиллагааны ахлагч, Хороо /

⁶ Ц.Оюунчимэг. “Монгол Улсын Зэвсэгт хүчний ахлагч бэлтгэх сургалт, түүнийг боловсронгуй болгох арга зам” цэргийн ухааны докторын диссертаци. УБ.2023 он;

⁷ Ц.Оюунчимэг. “Гадаадын зарим улсын ахлагч бэлтгэх сургалтын туршилага” Батлан хамгаалах аюулгүй байдал судлал сэтгүүл. 2024 он;

Тусгай батальон/-ны ахлагч зэрэг албан тушаал Сургагч болон Тэргүүн ахлагч цолыг бий болгож 2005 оны Ахлагчийг хөгжүүлэх хөтөлбөр, АНУ-ын ТЯЦ-тэй хамтарч явуулсан Удирдах албан тушаалын ахлагчийн удирдах ур чадварын хөгжүүлэх хөтөлбөр зэрэг нь ахлагчийн албаны хөгжлийг дэлхий нийтийн чиг хандлагатай уялдуулахад түлхэц болсон. Өнгөрсөн хугацаанд Ахлагчийн сургууль болон БХУА-ын түшиглэн Ахлагчийн Үндсэн, Гүнзгий, Дээд болон Ротын ахлагчийн дамжаа зэрэг Удирдах албан тушаалын ахлагчийн Шаталсан сургалтыг тасралтгүй зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн. АНУ-ын ТЯЦ-тай хамтарсан даргалах албан тушаалын ахлагчийн удирдах ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд ажилласан бүрэлдэхүүн өнөөдрийн даргалах албан тушаалын ахлагч нарыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулсан.

Манай Зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүний үндэс нь ахлагчийн бүрэлдэхүүн юм. НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын цэргийн баг үндсэндээ ахлагч нараас бүрдэх болов. Энэ бол Зэвсэгт хүчин мэргэжлийн армийн жишигт ойртож байгааг харуулж буй нэг үзүүлэлт мөн.⁸

2003 оноос эхлэн Энхийг сахиулах болон энхийг дэмжих ажиллагаануудын цэргийн багт үүрэг гүйцэтгэж буй ахлагч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, сахилга бат, зохион байгуулалт, нэр хүнд сайн байна. Харин олон улсын болон штабын түвшинд ажиллах ахлагч нарын гадаад хэлний болон онолын бэлтгэл чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай нь ажиглагддаг.

Одоогийн ахлагчийн сургалтын тогтолцоогоор ахлагч бүрэлдэхүүний 80 гаруй хувийг бүрдүүлдэг гүйцэтгэх албан тушаалын ахлагч нараа мэргэжлээр нь мэргэшүүлэх шаталсан сургалтын тогтолцоо бүрдээгүй, даргалах албан тушаалын ахлагчийн шаталсан сургалтаас өөр “дорвитой” шаталсан сургалт байхгүй байна.


Ахлагчийн алба хаагч нарын дийлэнх нь гүйцэтгэх албан тушаалын ахлагч байгаа тул гүйцэтгэх албан тушаалын ахлагч нарт тасралтгүй хөгжих, албандаа сэтгэл хоёрдолгүй ажиллах бололцоог сургалтын тогтолцоогоор дамжуулан олгох хэрэгтэй. Мөн гүйцэтгэх албан тушаалын ахлагч нарын дээд цол болох мэргэжлээрээ мэргэшсэн мастер ахлагч цолыг бий болгож, мэргэжлийн зэрэг, мэргэжлээрээ мэргэших шаталсан сургалтуудтай уялдуулах нь ахлагч нарыг албандаа тогтвортой ажиллах хөшүүрэг болно.

Түүнчлэн Зэвсэгт хүчний ахлагчийн сургалтын тогтолцоо, агуулга, хэлбэр олон улсын жишиг, өөрийн улсын онцлогт нийцсэн байхаас гадна **оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд тулгуурласан** байх нь хамгийн чухал

⁸ БХЯ. Монгол Улсын батлан хамгаалахын цагаан ном.-УБ.,Соёмбо принтинг. 2022;

юм. Өөрөөр хэлбэл, Батлан хамгаалах политехник коллежид элсэн суралцаж буй суралцагч түүний гэр бүл, цэргийн мэргэжилтнийг захиалагч, хэрэглэгч байгууллагын эрэлт хэрэгцээг нэгдмэл байдлаар тооцох шаардлагатай юм. Ингэснээр оролцогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан сургалтын бодлого, үзэл баримтлал хангагдах нөхцөл бүрдэнэ.

Зэвсэгт хүчний ахлагч нарын боловсрол, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, төлөвшил хандлагыг олгох эмх цэгц, эрэмбэ дараа бүхий шаталсан бүтэцтэй, батлан хамгаалах болон боловсролын тухай хууль тогтоомжид нийцсэн ахлагчийн сургалтын тогтолцооны дараах саналыг дэвшүүлж, нэгдүгээр зургаар харуулав.



1 дүгээр зураг. Ахлагч нарыг тасралтгүй хөгжүүлэх сургалтын тогтолцооны ерөнхий зураглал

Сүүлийн 5 жил Батлан хамгаалах политехник коллежид элсэгчдийн тоо багсаж, мэргэжил хяналтын тоо хүрэхгүй байгаа байдал, ахлагчийн албаны нэр хүнд үнэлэмжид анхаарах болсныг сануулж байна.

Гурав. Сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхэд ахлагчийн сургалтын үзүүлэх нөлөө

“Батлан хамгаалах тогтолцоонд сэргэлт хийж, эх оронч үзэлд суурилсан хүн төвтэй бодлого хэрэгжүүлж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлж буй энэ цаг үед ахлагч нарт “Хүн” талаасаа нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх хэрэгцээ шаардлага ямагт оршиж байдгийг анхаарч, ахлагчийн албаны нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн алхмаасаа ухрахгүй байхад анхаарах үйл ажиллагаануудыг санаачлан, зохион байгуулах хэрэгцээ, шаардлага өндөр байна.

Тиймээс, бид элсэгчдэд тавигдах шаардлага шалгуураа “эргэн харж” ахлагчийн албанд элсэх хүүхэд, залуучуудын сонирхлыг татах ухаалаг менежментийг хэрэгжүүлэх, бэлтгэсэн ахлагч нараа тасралтгүй хөгжүүлж, тогтвортой ажиллуулах боломжтой дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Өнөөгийн ахлагчийн сургалтын тогтолцоонд цэргийн мэргэжлээр бэлтгэсэн мэргэжилтнээ тасралтгүй хөгжүүлэх сургалтын бодлогод суурилсан даргалах албан тушаалд мэргэшүүлэх, мэргэжлээр нь мэргэшүүлэх гэсэн 2 үндсэн чиглэлд анхаарч одоогийн ахлагчийн сургалтын тогтолцоонд мэргэшсэн мастер ахлагч нарыг шатлан бэлтгэх сургалтуудыг нэмэх, бүх түвшний сургалтыг багц цагт дүйцүүлэн боловсролын зэрэг олгох, цэргийн мэргэжлийн зэрэгтэй уялдуулах;
- Сургалтын байгууллагыг орчин үеийн суралцагчдын сонирхол, сэтгэлгээний онцлог, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарах;
- Ерөнхий боловсролын сургуулиат төгсөөд цэргийн албыг түргэвчилсэн байдлаар хааж ахлагчаар элсэн суралцах нөхцөлийг бүрдүүлсэн, хугацаат цэргийн алба хаагчдаас улираах хэлбэрээр, цэргийн албаны хэрэгцээ шаардлагаар хэрэгцээтэй мэргэжлээр цэргийн бус байгууллагад ажиллаж байсан энгийн иргэдийг, анги байгууллагад шаардлагатай мэргэжлээр, коллежийн төгсөгч, оюутнуудтай гэрээ байгуулан ахлагчийн албанд элсүүлдэг зэрэг ахлагчийн нөхөн хангалтаа шийддэг гадаадын улс орнуудын ахлагчийн сургалтын туршлагаас өөрийн орны онцлог, эдийн засгийн нөөц боломжид тулгуурлан, авч хэрэгжүүлэх. Хугацаат цэргийн алба хаагчдыг ахлагчийн албанд орох давуу байдлыг бий болгох “Эх орны дуудлага эр цэргийн албанаас - Мэргэжлийн ахлагч” эрчимжүүлсэн, богино хугацааны мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг анги байгууллага, сургалтын байгууллага хамтран хэрэгжүүлж, ахлагчийн нөхөн хангалтаа нэмэгдүүлэх;
- Гадаадын ихэнх орны цэргийн сургуулиудад хамгийн эхний хичээлээ цэрэг армийн тухай түүхээ судлахаас эхэлдэг нь офицер, ахлагч нартаа эх оронч үзэл төлөвшүүлэх нэг хэлбэр юм. Зэвсэгт хүчний анги салбаруудад ажиллах ирээдүйн офицер ахлагч нарт ёс суртахууны зөв хүмүүжил олгоход сургалтын байгууллага өндөр үүрэг хүлээж, манлайлан ажиллах;
- Гадаадын ахлагчийн сургалтын тогтолцоонд байдаг Мэргэшсэн ахлагч буюу Варрант офицер, Мастер ахлагч болон сургагч багш бэлтгэх сургалтуудыг нэвтрүүлэх, цэргийн сургалтын онцлог, зарчимд тулгуурласан арга технологийг багш нарт олгох;

- Онц сайн дүнтэй төгссөн ахлагч нар нь дараагийн албан тушаал, цол хэргэмд бусад ахлагч нараас түрүүлж дэвших боломжийг олгох, үнэлгээний нэгдсэн систем нэвтрүүлэх;
- Өнөөгийн бидэнд учирч болох аюул занал зөвхөн гаднын улс орны цэрэг, зэвсгийн хүчээр хийх уламжлалт зэвсэгт түрэмгийллээр хязгаарлагдахгүй болсон. Крым болон Украины хэрэг явдлаас харахад түрэмгийлэгч улс нь аливаа улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлэхдээ өөрийн төлөөний хүчин /proxу forces/-ийг ашиглаж байгаа нь бидний мэдэх дайсагнагч улсаас цэргийн хүчээр эзлэн түрэмгийлэл үйлдэх гэсэн уламжлалт ойлголт өөрчлөгдөж байгааг харуулж байна.⁹ Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд, залуучууд, иргэдэд эх оронч үзэл, эх орноо батлан хамгаалах боловсрол олгох, цэргийн мэргэжлийг сурталчлах “Хэн ч надаас илүү мэргэжлийн байж чадахгүй” богино хугацааны, сонирхолтой сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Дүгнэлт

Өнөөгийн цэргийн урлагийн хувьсал өөрчлөлтийн дагуу мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин мэргэжлийн өндөр ур чадвартай мэргэшсэн ахлагч нарыг бэлтгэхдээ цол, албан тушаалаас гадна мэргэжлийн болон боловсролын зэрэгтэй уялдуулсан тасралтгүй сургаж шаталсан сургалтын тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байна. Ингэснээр батлан хамгаалах бодлого зорилтод нийцсэн мэргэшсэн ахлагчийн нөөцөө бүрдүүлэхээс гадна тэднийг тогтвортой ажиллуулах боломж бүрдэнэ.

Гадаадын өндөр хөгжилтэй орнуудын ахлагч нарын сургалтын туршлагаас мэргэжил, албан тушаалд мэргэшүүлэх богино хугацааны шаталсан сургалтуудаар мэргэшсэн мастер ахлагч бэлтгэх, даргалах албан тушаалын ахлагч нарын нөлөөлөл, хариуцлага хүлээх чадамжийг нэмэгдүүлэх, сургагч ахлагч нарын заах арга зүйг сайжруулдаг арга барил, ахлагчийн албанд элсэхэд хугацаат цэргийн албанаас элсэгчдэд давуу байдал олгох, богино хугацаатай уян хатан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Судалгааны илтгэлээр санал болгосон хугацаат цэргийн алба хаагчдыг ахлагчийн албанд орох давуу байдлыг бий болгох “Эх орны дуудлага эр цэргийн албанаас - Мэргэжлийн ахлагч” эрчимжүүлсэн, богино хугацааны мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр цэргийн албанд ирэх залуусын тоо нэмэгдэхээс гадна, ахлагчийн нөхөн хангалтаа нэмэгдүүлэх эерэг өөрчлөлт гарна гэж үзэж байна.

⁹ “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал” Swedish Defense University орчуулгын бүтээл.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд, залуучууд, иргэдэд эх оронч үзэл, эх орноо батлан хамгаалах боловсрол олгох, цэргийн мэргэжлийг сурталчлах “Хэн ч надаас илүү мэргэжлийн байж чадахгүй” богино хугацааны, сонирхолтой сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр батлан хамгаалах үйл хэргийг олон нийтэд сурталчлах, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, тэднийг эх орныхоо төлөө хариуцлагатай иргэн болгон бэлтгэх нь нийгмийн хөгжлийн нэгэн тулгуур болно. Цэргийн сургалтын тогтолцооны шинэчлэл нь залуусын ур чадварыг нэмэгдүүлэх, цэргийн бэлтгэлийг сайжруулах ач холбогдолтой бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нь улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй хэмээн дүгнэж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл

1. <https://president.mn/> Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудас. 2025 оны мэдээлэл;
2. “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. 2.2 заалт;
3. “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 127 дугаар тогтоолын хавсралт.3.1 заалт;
4. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
5. “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал” Swedish Defense University орчуулгын бүтээл;
6. Ц.Оюунчимэг. “Монгол Улсын Зэвсэгт хүчний ахлагч бэлтгэх сургалт, түүнийг боловсронгуй болгох арга зам” цэргийн ухааны докторын диссертаци. УБ.2023 он
7. Ц.Оюунчимэг. “Гадаадын зарим улсын ахлагч бэлтгэх сургалтын туршлага” Батлан хамгаалах аюулгүй байдал судлал сэтгүүл. 2024 он;
8. БХЯ. Монгол Улсын батлан хамгаалахын цагаан ном.-УБ.,Соёмбо принтинг. 2022;
9. “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал” Swedish Defense University орчуулгын бүтээл.